

Монгол-Германы харилцааны үечлэл

Эдийн засгийн ухааны доктор (PhD)
Олхонууд овогт Р.Жамц

Өнөө үед Монгол-Германы харилцаа, улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн бүх салбарт идэвхжин эрчимтэй хөгжиж байна. Монгол-Германы ард түмнүүдийн хоорондын харилцаа, харилцан бие биенээ мэдэх болсон явдлыг түүхийн үүднээс хөөж үзвэл хэдэн зууны тэртээд хамаарагдах бөлгөө. Энэхүү харилцаа нь олон зуун жилийн уламжлалтай, бие бие үрүүгээ тэмүүлэх шинж онцлог ямагт байсан авч, цаг үеийн түүхийн бэрхшээл, нугачаанаас улбаалан нэг үе идэвхжин, нэг үе тасалдаж байсан түүхтэй.

Монгол-Германы харилцааг тухайн үеийн онцлогтой нь судлахын тулд уг харилцааг дараахь байдлаар үечлэн авч үзэх нь зүйтэй юм.

Нэгдүгээр үе. Германчууд монголчуудын тухай мэдэх болж, Монгол-Германы харилцааны ээхлэл тавигдсан нь /XIII-XIX зууны эцсийн үе/ Монголчууд анх 1206 онд Есүхэй баатрын хүү Тэмүүжинг Нэгдсэн Монгол улсын хаанаар өргөмжилж “Чингис” цол хүртээжээ.

Чингис хаан Монголын тулгар төрийг үндэслэн байгуулсныхаа дараа өөрийн цэргийг Орос, Киев, Мажар /Унгар/ зэрэг Баруун Европын орнуудад илгээх зарлиг буулгаж, уг зарлигийг түүнийг тэнгэрт хальсны дараа түүний үе залгамжлагч хүү игийдэйн даалгавраар Чингисийн ач хүү Батхаан удирдан гүйцэтгэсэн түүхтэй. Энэ бол Монгол-Германы харилцааны эхлэлийг тавьсан гэж үзэх үндэслэлтэй.

Батхаан Өрнөд Европт тулж очоод 1240-41 оны үед Германы эзэн хаан II Фридрихтэй захидал солилцсон. Батхааны удирдсан монгол цэргүүдийн хээсэг Германы нутгаар дайран өнгөрөхөд 1241 онд Лийгнец хотын орчимд Герман, Польшийн хҮч, монголчуудын хооронд ширүүн тулалдаан болсон гэж түүхэнд бичигдсэн байдаг. Чухамхүү 1240-41 оноос монголчууд болон германчууд анх бие биенээ мэдэх болсон байна. Үүнээс хойш гадаадын болон Германы аялан жуулчлагчдын замын тэмдэглэл, дурсамж зэргээс германчууд Монголын талаар тодорхой мэдэх болж улмаар Германы эрдэмтэд Монголыг судлах ажил эхэлж, олон ном зохиолыг бичих болсон зэрэг нь Монгол-Германы харилцааны эхлэлийг бататгахад нөлөөлөх болсон түүхтэй гэж үзнэ.

Хоёрдугаар үе. /XX зууны эхэн-1938 он/ Монгол-Германы харилцааны бодит эхлэлийн үе. Энэ үечлэлд XX зууны эхний

хагасаас 1938 он хүртэлх хугацаа хамаарагдах юм. Энэ нь Германы капитал Монголд анх нэвтэрч, худалдааны харилцааны эхлэл тавигдаж, Германы тусламжтайгаар зарим үйлдвэр аж ахуйн газрууд баригдсан, Германд анхны монгол оюутан сурагчдыг сургах болсон, 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, Монголын автономит төрийг байгуулсан үед, 1921 оны ардын хувьсгалын дараа Монголын төр засгийн удирдлагууд Германтай холбоо тогтоож, тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, тэдний дэмжлэгийг олох гэсэн оролдлогууд хийсэн үеүдтэй давхцаж байна.

Гүравдугаар үе. /1938-1950/ Энэ хугацаанд БНМАУ, Германы харилцаа бүрэн зогссон юм. Энэ нь Германд фашист харгис дэглэм тогтож, дэлхийн II дайн эхэлсэн, Гитлерийн фашист Герман итгэлийг эвдэн, ЗХУ-ын эсрэг гэнэт довтолж, ЗХУ-ын эх орны дайн эхэлсэн үе юм. БНМАУ нь Гитлерийн Германы өдөөсөн энэхүү дайны үед фашизмын эсрэг ЗХУ-ын Улаан армийг дэмжин Зөвлөлтийн ард түмэнд эд материалын болон сэтгэл санааны бодитой тусламж үзүүлсэн түүхтэй.

Дөрөвдүгээр үе. /1950-1990 он/ Энэ үе нь дэлхийн II дайны дараахь Монгол-Германы харилцаа юм. Дэлхийн II дайны уршгаар хоёр туйлт дэлхийн систем бий болж, Герман нь баруун, зүүн гэсэн хуваагдмал улс болж, эсрэг тэсрэг хоёр системд хамаарагдах болсон юм. Гэсэн ч Монгол улс нь Герман үндэстний хоёр улстай аль алинтай нь дипломат харилцаа тогтоож, Германд харгис дэглэм тогтсоноор 1938 онд зогссон хоёр улсын харилцааг шинэ нөхцөл байдалд дахин сэргээх болсон үе байлаа.

Тавдугаар үе. /1990 оноос хойшхи үе/ Энэ үеэс Монгол ба Нэгдсэн Германы харилцаа хамтын ажиллагаа цоо шинэ нөхцөл байдалд түргэн хурдацтай хөгжиж, харилцааны эрх зүйн үндэс нь шинэчлэгдэн бэхжиж, улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн харилцаа зэрэг нийгмийн амьдралын бүхий л салбарыг хамран хөгжих болсон юм.

1990 онд хоёр Герман нэгдэж, нэгдсэн Герман улс байгуулагдсан түүхэн үйл явцтай, Монголд ардчилсан хувьсгал тайван замаар явагдаж, хуучин систем эцэс болж, улс орон чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжин, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулах болсон үйл явдал цаг хугацааны хувьд давхацсанаар Монгол, Германы харилцаа энэхүү түүхэн шинэ нөхцөл байдалд нийцэн эрчимтэй хөгжих болсон юм.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “Монгол Улсын гадаад бодлогын хоёр дахь чиглэл бол АНУ, Япон, ХБНГУ зэрэг орно,

дорнын хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх явдал юм” гэж заасан ба одоогийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт Монгол Улсад ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог хөгжүүлэх зорилтыг хангахад ХБНГУ-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх тухай тус тус заасан билээ. Монгол улс ийнхүү нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулж эхэлснээр гадаад ертөнц, юуны өмнө ернийн өндөр хөгжилтэй орнуудтай хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн нийтлэг үнэлэмжид тулгуурласан харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх чиг бодлогын хүрээнд ХБНГУ-тай идэвхтэй харилцахыг зорьсон нь 1990-ээд оноос хойш өнөө үед хэрэгжих боллоо. Монгол-Германы харилцааны шинэ үе-1990-ээд оноос хойшхи хугацааг авч судлахдаа дараахь байдлаар үечлэн авч үзэж болно. Үүнд:

Нэгдүгээрт. Хоёр орон харилцааныхаа өнгөрсөн үеийг дүгнэн, олон жилийн уламжлалт, бие бие рүүгээ тэмүүлэн ирсэн харилцааг шинэ нөхцөл байдалд зохицуулан идэвхтэй хөгжүүлэх зорилгын үүднээс харилцааныхаа бодлогыг тодорхойлсон мөч.

Хоёрдугаарт. Харилцааныхаа хууль, эрх зүйн үндсийг боловсруулж хэрэгжүүлсэн үе.

Гуравдугаарт. Дээрх хоёр нөхцлийн үндсэн дээр харилцаа улс төр, эдийн засаг, худалдаа, соёл боловсрол, шинжлэх ухаан, хүмүүнлэг зэрэг улс нийгмийн бүх салбарт идэвхтэй хөгжиж өргөжсөн гэсэн ерөнхий байдлаар авч үзэж болох талтай ч Монгол, Германы 1990-ээд оны харилцааг судлаачид бүхэлд нь бүр тодорхой гурав хуваан үзсэн нь үнэн байдалд дүйцэх бодитой дүгнэлт юм. Үүнд:

Нэгдүгээрт. 1990-1994 он. Нэгдсэн Герман улс хуучин БНАГУ-ыг өвлөн авсны хувьд манай улсын талаар хүлээсэн үүрэг хамтран ажиллаж байсан салбаруудаас алийг нь үргэлжлүүлэхээ товлон тогтоох, үр ашиггүй гэж үзсэнээсээ татгалзахын зэрэгцээ хамтын ажиллагааны шинэ чиглэлүүдийг тодорхойлсон алхмуудыг хийж эхэлсэн юм. Энэ хугацаанд манайхаас Монгол Улсын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн, УИХ-ын дарга Н. Багабанди, Гадаад Харилцааны сайд Ц. Гомбосүрэн болон Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүд ХБНГУ-д айлчилсан бөгөөд ХБНГУ-аас Бундестагийн дэд Ерөнхийлөгч Д. Ю. Кроненберг, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны сайд К. Д. Шпрангер, Гадаад Хэргийн Яамны төрийн сайд Х. Шэфер нар айлчилж, Парламент, Засгийн газрын түвшинд өндөр хэмжээний яриа хэлцээний эхлэлийг тавьсан юм. Монголоос Зүүн Германд тэдний Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байсан 500 гаруй оюутан сурагчдыг үргэлжлүүлэн сургаж төгсгөснөөс гадна малын хортон шимэгчидтэй тэмцэх арга хэмжээ зэрэг уламжлалт төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Хөгжлийн зориулалттай зээл, тусламж

олгож эхэлсэн бөгөөд эхэн үедээ Бороогийн алтны орд газар, Борнуурын САА зэрэг объектууд дээр анхаарч байснаа зогсоож эрчим хүч болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зэрэг шинэ салбар уруу орсон билээ.

Хоёрдугаарт 1995-1999 он. Энэ үед хамтын ажиллагааны үндсэн салбаруудад тодорхой ахиц гарч, шинэ боломжууд нээгдэн, тэдгээрийг ашиглах бодит эхлэл тавигдаж Монгол, Германы харилцаа эрс идэвхтэй, уур амьсгал нь итгэмжилсэн шинжтэй болж ирсэн бөгөөд хамтын ажиллагааны түншийн хувьд бие биеэ илүү гүнзгий танин мэдэж, итгэх болсон юм. Нөгөөтэйгүүр 1996 оны УИХ-ын сонгуулийн дараа төрийн эрх мэдлийг улс төрийн нэг хүчнээс нөгөө хүчний гарт шилжүүлэх үйл явц элдэв хүндрэл бэрхшээлгүйгээр явагдсан нь Монголын ард түмэн ардчилсан чөлөөт сонголтоо жам ёсоор нь хийж чадаж байгааг төдийгүй Монголын нийгэм ардчилал, зах зээлийн эдийн засгийн замаар хэлбэрэлтгүй замнах зориг эрмэлзэл төгс байгааг дэлхий дахинд харуулсан явдал манай шинэ чухал түнш ХБНГУ-ын итгэлийг олоход нааштай нөлөөлсөн гэж үзэж болох юм. Барууны тэргүүний хөгжилтэй ардчилсан орнууд, ялангуяа Их-7 хэмээн нэрлэгддэг байсан орнуудаас төрийн тэргүүн нь Монголд айлчилсан, харилцааны тулгуур баримт бичиг байгуулсан анхны орон бол Герман бөгөөд эдгээр үйл явдлууд нь хоёр талын харилцааны хувьд чухал байсан төдийгүй Монголын олон улсын нэр хүндийг цаашид дэлгэрүүлэхэд үзүүлсэн томоохон дэмжлэг болсон гэж үзүүштэй. 1995-99 онд Монголд үзүүлсэн зээл тусламжийн хэмжээ жилээс жилд өсч өмнөх 4 жилээсээ бараг 2 дахин нэмэгдэн уламжлалт салбараас гадна харилцаа холбоо, эрчим хүч, байгаль орчин, эрх зүйн шинэчлэл зэрэг шинэ шинэ салбаруудыг хамрах болсон юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч 1995 онд ХБНГУ-д, Холбооны Ерөнхийлөгч 1998 онд Монголд харилцан айлчилснаар улс төрийн харилцаа хамгийн өндөр төвшиндээ хүрсэн төдийгүй нийт харилцааг шинэ төвшинд гаргасан билээ.

Монголын талаас УИХ-ын дарга Гадаад хэргийн сайд болон Парламент, Засгийн газрын гишүүд айлчилсан бөгөөд Германы талаас Холбооны дэд канцлер бөгөөд Гадаад хэргийн сайд К. Кинкель, Бундестагийн дэд ерөнхийлөгч болон байнгын хороодын төлөөлөгчид, яамдын төрийн нарийн бичгийн дарга зэрэг өндөр зиндааны төлөөлөгчид Монголд зочлон харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээ тэлж ирсэн юм. Муж, улс, аймгийн болон хотуудын шууд хамтын ажиллагааны уламжлалыг сэргээж, зарим хэлбэрийг шинээр хөгжүүлэн эхэлсэн билээ. 1995 онд “Харилцааны үндсийн тухай тунхаглал” хэмээх тулгуур баримт бичиг байгуулсан нь хоёр талын

харилцааны эрх зүйн үндэс суурийг бататгахад чухал түлхэц болсон юм. Монгол, Германы харилцаанд оролцогчдын тоо нэмэгдэж, Засгийн газар, Парламентын хүрээнээс халин олон нийтийн байгууллага, муж улс, аймаг, хот, орон нутгийн удирдлага, улс төрийн сангуудыг хамран амжилттай хөгжих болсон билээ.

Гуравдугаарт 1999 оноос хойшхи үе. 1998 оны шувтаргаар ХБНГУ-д болсон сонгуулийн ГСДН/Ногоонтны намын эвсэл байгуулагдсанаар 16 гаруй жил засгийн эрх барьж байсан ХАХ/ХНХ солигдож тэд сөрөг хүчний байранд очсон юм. Өөрөөр хэлбэл, Монголтой хамтын ажиллагаа тууштай хөгжүүлж байсан барууны үзэл бүхий улс төрийн хүчний оронд зүүний чиглэлтэй засгийн газар гарч ирэн өмнөх Засгийн газар, Парламентын үед хэрэгжиж байсан үйл ажиллагаанд дүгнэлт хийж, өөрийн өнгө аяс, чиг шугам бүхий бодлогоо явуулах нөхцөл бүрдсэн билээ. ХБНГУ-ын шинэ засгийн газар өдгөө манай харилцааны залгамж чанарыг хадгалан хөгжүүлэх боллоо. Хамтын ажиллагаа нь үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр ч санаа тавьсаар тодорхой алхмууд хийсээр байна.

Монгол-Германы хамтын ажиллагааг бүх өргөтгөн, бодит үр дүнд хүргэхэд сүүлийн жилүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхий сайд Н.Энхбаяр нарын ХБНГУ-д хийсэн албан ёсны айлчлал, айлчлалын үеэр Германы төр засгийн удирдлагуудтай уулзаж хэлэлцсэн асуудлууд, хэлэлцээрүүд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

Ашигласан материал, ишлэл

1. Р.Жамц, Монгол-Германы харилцаа: эрт, эдүгээ, Улаанбаатар, 2003
2. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа, Улаанбаатар, 1995
3. Монгол-Татаарууд Ази, Европт, Улаанбаатар, 1984
4. Ч.Далай, Монголын түүх, Дэд дэвтэр, Улаанбаатар, 1994
5. Ч.Далай, Монголын түүх: Их Монгол улс, Гутгаар дэвтэр, Улаанбаатар, 1992
6. Л.Н.Гумилёв, Древняя Русь и Великая Степь, Москва, 1984, 505-р тал.
7. Л.Хайсандай, Чингис хаан ба Их Монгол Улсын гадаад харилцаа, Олон Улс сэтгүүл, Улаанбаатар, 2(2002).
8. Гадаад харилцаа (Монгол Улсын Гадаад Хэргийн Яамны мэдээллийн товхимол), Улаанбаатар, 11(2001).